

# Э-Сонин

39 дахь дугаар

2016 он 3 сар



## Мэдээний Тойм



### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

#### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР



#### ТӨРИЙН ӨНДӨР ДЭЭД ОДОН, МЕДАЛЬ АВСАН МЭРГЭЖИЛТНҮҮДДЭЭ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

#### “АЙ ТҮҮЛС” ХК-ИЙГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН “II” АНГИЛАЛД БҮРТГЭЛЭЭ



#### “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН @StockExchangeMN ТВИТЭР ХУУДАС

#### IPO ХЭРХЭН ХИЙХ ТАЛААР СЕМИНАР БОЛЖ ӨНГӨРӨВ



#### М.БОЛОР: КОМПАНИУД НЭГДЭЖ БАЙЖ Л ҮЛДЭНЭ

#### "ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

### ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- ЗГЖҮЦ-ны 3 дугаар сарын арилжааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн мэдээлэл.
- 2016 оны 3-р сард тов нь гарсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар.
- Төрийн одон медаль авсан мэргэжилтэнүүддээ Монголын хөрөнгийн биржийн удирдлага хүндэтгэл үзүүллээ.
- “Ай Түүлс” ХК-ийг Монголын хөрөнгийн биржийн “II” ангилалд бүртгэлээ.
- IPO хэрхэн хийх талаар семинар болж өнгөрлөө.
- М.Болор: Компаниуд нэгдэж байж л үлдэнэ.
- “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох ээлжит сургалт өндөрлөлөө.

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 3-р сарын арилжааны мэдээ

### СУРГАЛТ

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт-ыг 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр явуулахаар төлөвлөж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг  
11-323715—3314 дугаараас авна уу.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

### АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны /Нэгжийн үнэ 100,000 төгрөг/ захиалгыг долоо хоног бүрийн Мягмар гарагаас дараа долоо хоногийн Даваа гараг хүртэл авч, арилжааг зохион байгуулж байна. Гуравдугаар сард тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 4 удаа зохион байгуулж нийт 13.7 тэрбум төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2016.03.07	ЗГХБ-Б-28-360	28	31,386	14.930%	2,905,653,108
2016.03.07	ЗГЭБ-У-156-361	156	9,000	15.75%	900,000,000
2016.03.14	ЗГХБ-Б-39-362	39	969	14.915%	87,175,116
2016.03.21	ЗГХБ-Б-12-364	12	72,168	14.50%	6,983,769,528
2016.03.28	ЗГХБ-Б-52-366	52	32,408	14.941%	2,820,533,056
<b>НИЙТ ЗАРАГДСАН ЗГҮЦ</b>			<b>145,931</b>		<b>13,697,130,808.00</b>

### ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны хоёрдогч үнэт цаасны арилжаа 2016 оны 3 сард нийт 6 удаа явагдаж 1,101 ширхэг буюу 107.7 сая төгрөгний ЗГҮЦ-ны гүйлгээ хийсэн байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Нэгж үнэ	Үнийн дүн /төгрөг/
2016.03.11	ZGEB-BL-25/07/16-A0094-0	10	94,500	945,000
2016.03.15	ZGEB-BL-31/08/16-A0108-0	20	93,550	2,058,100
2016.03.22	ZGEB-BL-16/05/16-A0111-0	903	98,000	88,494,000
2016.03.22	ZGEB-BL-16/05/16-A0111-0	11	98,000	1,078,000
2016.03.28	ZGEB-BL-16/05/16-A0111-0	152	98,090	14,909,680
2016.03.28	ZGEB-BL-25/07/16-A0094-0	3	95,300	285,900
<b>НИЙТ ЗАРАГДСАН ЗГҮЦ</b>			<b>1,101</b>	<b>107,770,680</b>

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

### ГОВЬ ХК

“Говь” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 4-р сарын 8-ны өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцэнэ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2015 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанид шинээр нэвтрүүлээд байгаа “Амеб” менежментийн явц, үр дүнг танилцуулах
3. 2014 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2015 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-н шийдвэрийг танилцуулах
4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, батлах  
ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийг батлах

### БАГАНУУР ХК

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2016 оны 4-р сарын 11-ний өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцэнэ:

1. Нэмж гаргах хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх,
2. Тэргүүн ээлжинд худалдан авах хувьцааны үнэд хуулинд заасан хэмжээнд хөнгөлөлт эдлүүлэх эсэх,

### ЗООС ГОЁЛ ХК

“Зоос Гоёл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2016 оны 4-р сарын 22-ний өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцэнэ:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон хувьцаа нэгтгэх төслийн хэрэгжилтийн үр дүнгийн тухай,
2. Компанийн 2015 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл, түүнд хийсэн ТУЗ-ийн /Аудитын хорооны/ дүгнэлтийн тухай
3. 2015 оны цэвэр ашигаас нэгж хувьцаанд 17,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилах тухай,  
ТУЗ-ийн өнгөрсөн жилийн бүрэн эрхийн хугацаа /2015.05 сар – 2016.04/-ны зардлын гүйцэтгэл, ирэх оны /2016.06сар – 2017.04 сар/ зардлын төсвийг батлах тухай

### МИК ХОЛДИНГ ХК

“Мик Холдинг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2016 оны 4-р сарын 28-ний өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцэнэ:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
3. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай  
Компанийн ТУЗ-ийн зардлын 2016 оны төсвийн төслийг батлах

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

### ТАЛЫН ГАЛ ХК

“Талын гал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 4-р сарын 29-ны өдөр 11:00 цагаас Баруун-Урт сумын 9 дүгээр багийн нутагт орших тус компанийн хурлын танхимд болно.

### РЕМИКОН ХК

“Ремикон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 4-р сарын 28-ны өдөр 11:00 цагт “Хера Индастриал парк”-ийн байранд хуралдахаар боллоо. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. хуралдаж дараах асуудлыг хэлэлцэнэ:

1. Компанийн 2015 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
2. Компанийн 2016 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөтэй танилцах
3. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу компанийн ТУЗ-ийн гишүүдийн эрхийг сунгах, томилох
4. 2015 оны санхүүгийн жилийн ашгаас Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах Монгол Улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу ТУЗ үйл ажиллагаа санхүүгийн тайлангаа танилцуулах

### ДАРХАН ХӨВӨН ХК

“Дархан Хөвөн” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 3-р сарын 21-ны өдрийн 16:00 цагт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 6-р хороо, бага тойруу, Монрегийн 305 тоот өрөөнд болж өнгөрлөв.

Уг хуралд нийт хувьцаа эзэмшигчдийн 33.5%-ийн хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул Компанийн тухай хуулийн 69.3 заалтыг үндэслэж хурлыг 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдөр 16 цагт дээрхи байранд дахин хуралдуулахаар хойшлогдов.

## ТӨРИЙН ӨНДӨР ДЭЭД ОДОН, МЕДАЛЬ АВСАН МЭРГЭЖИЛТНҮҮДДЭЭ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн болон МҮЦАЭХ-ны удирдлагууд Монгол улсад Хөрөнгийн зах зээл үүсч Монголын хөрөнгийн бирж байгуулагдсаны 25-н жилийн ойг тохиолдуулан Төрийн одон медалиар шагнагдсан хүмүүсээ хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

### Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор:

- “Алтан хоромсог” ҮЦК-ийн захирал Тогоочийн Монхор

### Алтангадас одонгоор:

- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Захиргаа Аж Ахуйн албаны захирал Б.Нарантуяа
- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Захиргаа Аж Ахуйн албаны ажилтан Б.Энхболд
- "МҮЦАЭХ"-ны гүйцэтгэх захирал асан Лхамсүрэнгийн Цэвээнравдан
- "Зэргэд" ҮЦК-ийн захирал Шагдарын Эрдэнэ
- "Дархан брокер" ҮЦК-ийн захирал Жамбалын Очирсүх

### Хөдөлмөрийн хүндэт медалиар:

- "Монсек" ҮЦК-ийн захирал Манханы Отгонбаатар
  - "Санар" ҮЦК-ийн захирал Мягмарын Бүрэнбаяр
  - "Дэлгэрхангай секьюритис" ҮЦК-ийн Далхаагийн.Бат-Эрдэнэ
  - "Масдак" ҮЦК-ийн захирал Ванданлуvsан Баттулга
  - "Булган брокер" ҮЦК-ийн захирал Далхжавын Амгалан нар тус тус шагнал хүртлээ.
- Шагнал хүртсэн нийт хүмүүсийнхээ цаашдын ажил амьдралд нь өндөр амжилт хүсэн ерөөе.





“АЙ ТҮҮЛС” ХК-ИЙГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН  
“II” АНГИЛАЛД БҮРТГЭЛЭЭ




Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 1 дугаар сарын 29-ний 20 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг тус тус үндэслэн 2016 оны 3 дугаар сарын 03-ны өдөр “Ай Түүлс” ХК-ийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 4,324,263 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн II-р ангилалд бүртгэн авлаа.

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН  
@StockExchangeMN ТВИТЭР ХУУДАС



Монголын хөрөнгийн биржийн албан ёсны Twitter хуудас Mongolian Stock Exch @StockExchangeMN-ийг дагаснаар бодит цагийн горимоор арилжааны болон бусад мэдээллийг авах боломжтой.



The screenshot shows three tweets from the account @StockExchangeMN. The first tweet reports on the listing of 'Tavan Tolgoi' LLC shares, mentioning 12,073 shares and a total value of 10,503,510,000 MNT. The second tweet discusses the trading volume of ZGUC shares, stating that 28% of the daily trading volume was accounted for by ZGUC shares, with 200,440 shares traded. The third tweet mentions that 15.75% of the daily trading volume was accounted for by ZGUC shares, and that the trading volume will be capped at 11:00.

**IPO ХЭРХЭН ХИЙХ ТАЛААР СЕМИНАР БОЛЖ ӨНГӨРӨВ**



2016 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ болон Монголын хөрөнгийн бирж /МХБ/ нарын хамтран зохион байгуулсан “Хувьцааг олон нийтэд санал болгох (IPO) болон давхар бүртгэл(dual listing)”-ийн 2 дахь удаагийн сургалт “Туушин Бэст Вэстэрн” зочид буудалд болж өнгөрлөө.

Тус семинарын үеэр ЖАЙКА-гийн зөвлөх багийн дарга Рьёта Шугишита, Азийн бизнес стратеги төлөвлөлтийн захирал Сейжи

Адач, болон Монголын хөрөнгийн биржийн захирлын үүрэг гүйцэтгэгч М.Болор нар Монголын Улсын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, хөрөнгийн зах зээлийн шинэчлэл, үнэт цаасыг олон нийтэд нээлттэй санал болгох талаар илтгэл тавилаа.





## М.БОЛОР: КОМПАНИУД НЭГДЭЖ БАЙЖ Л ҮЛДЭНЭ

**-Манай компаниудын бүтцийг харвал их сонирхолтой тоо харагдаж байна. Монголын хөрөнгийн бирж хөгждөггүй шалтгаан нь үүнтэй холбоотой юу. Бид ер нь хаана явна аа?**

-Манай эдийн засгийн нийт хэрэглээ маань хоёр дахин буурчихсан. Түүнээс гадна хөрөнгө оруулалт гурав дахин, Засгийн газрын хэрэглээ нь 1,5 дахин, импорт маань бас 1,5 дахин буурчхаад байна. Энэ утгаараа манай эдийн засгийн өсөлт одоогоор 2,4 хувьтай байна.

**-Цагийн сайхан хоёр оронтой өсөлттэй байсан даа?**

-Тийм ээ, цагийн сайханд 17,5 хувийн өсөлттэй байлаа шүү дээ. Одоо бол өсөлт саарчихсан. Өсөлт саараад ирэхээр компаниуд бараагаа зарж чадахгүй болохоор дотоод зардлаа танаж таарна. Цомотгол хийж байна. Аливаа бизнесээ эхлүүлэхдээ харзнаж, ажиглах байдалтай болчихсон. Ингээд хэмнэлтийн горимд орчихсон нөхөд чинь бизнесээ хийж чадахгүй байна. Бүгдээрээ дансандаа мөнгөө барьчхаад одоо юу болох вэ гээд хүлээгээд суучихлаа.

**-Зээл олгохоо ч байсан гэсэн.**

-Одоогоор моргежийн бага хэмжээний, хэрэглээний, цалингийн, тэтгэврийн, малчдын гээд зээл л олгогдож байна. Зээл олгож байна гэдэг идэвхжүүлэх ганц арга нь байгаа ч хангалттай хэмжээнд биш. Нэг талаасаа санхүүжилтээр бид суучихаад байгаа юм байна. Нөгөө талаасаа бизнесийнхэн маань хөрөнгө оруулалт хийлээ гэхэд хэндээ бүтээгдэхүүнээ борлуулах вэ гэсэн айдастай байгаа болохоор аль аль талдаа суучихаад байгаа юм. Эдийн засаг санхүүгийн хувьд тиймэрхүү байна.

**-26 жил бид чөлөөт эдийн засгийн замналаар замнаж ирлээ. Гэхдээ бүх зүйл маань тийм байсангүй. Одоо төвлөрсөн**



**төлөвлөгөөт эдийн засгаа ч санагалзаж байх шиг. Бид юун дээр алдчихав аа?**

-Эргээд харахад нэг зүйл ажиглагдаж байна. Энэ хүртэл явж ирсэн бизнесийн түүх гэж яривал бид “Чингис”, “Самурай”, өмнө нь татсан бонд, түүнээс гадна Худалдаа хөгжлийн банкны гаргасан бонд гээд тодорхой хэмжээний мөнгө босголоо шүү дээ. Энэ босгосон мөнгөөр ямар хөрөнгө оруулалт хийсэн бэ гэхээр аж үйлдвэр шинж чанартай хөрөнгө оруулалт хийсэн. Өөрөөр хэлбэл, тоног төхөөрөмжөө худалдаж аваад үйлдвэрүүд маань чанаржсан. Түргэн эргэдэг биш, суурь хөрөнгө оруулалт хийсэн гэсэн үг.

**-Ерөнхий бааз суурь байхгүй учраас түүндээ зарцуулж л дээ?**

-Өмнө нь эргэлтийн хөрөнгөдөө хөрөнгө

оруулалт хийгээд тодорхой хэмжээгээр өсөөд байдаг байсан. Тэгсэн хуучин байсан тоног төхөөрөмжийнхөө дээд хүчин чадалд хүрмэгц нэг шаардлага гарч ирсэн. Тухайн үед түүхий эдийн үнэ сайн байсан. Энэ үед манайхан томоохон экспортоос олж ирсэн орлогоо яасан бэ гэхээр эргэлтийн биш аж үйлдвэр, боловсон хүчний суурь хөрөнгө оруулалтаа хийсэн. Энд ямар алдаа гаргасан бэ гэхээр богино хугацааны хөрөнгө оруулалтын хөрөнгөө авч үлдээгүйгээр тэр чигт нь үйлдвэрт хөрөнгө оруулчихсан.

**-Үйлдвэр нь ашиглалтад орчихдог. Цааш үйл ажиллагаа явуулах мөнгөгүй болчихсон гэсэн үг үү?**

-Түүхий эдээ татах хөрөнгөгүй, боловсон хүчнээ цалинжуулах мөнгөгүй, тээвэрлэлтээ даах чадалгүй сууж байна. Юу ч хийхэд бэлэн болчихсон ч богино хугацааны хөрөнгө оруулалтгүй суучихсан. Дээр нь бүх салбарт маш олон ажилчдыг цомхотгосон байдал маань эргээд нийт худалдан авалтаа унагачихсан. Ямар ч бизнес эцэстээ эцсийн хэрэглэгчид очдог биз дээ. Гэтэл эцсийн хэрэглэгчид нь ажилгүй, ажилгүй учраас мөнгөгүй болчихоор худалдан авалт хийж чадахгүй. Дээр нь бүх үйлдвэрүүд ашиглалтад орсон гэвэл хэцүү. Аливаа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийн тулд 10-20 субъект орж байж л бараа гаргадаг. Гэтэл зарим салбар нь гацчихсан. Гэхдээ энэ том асуудал биш. Үндсэн асуудал нь богино хугацааны хөрөнгө оруулалт байгаа юм.

**-Дээр нь бидний бизнес хийдэг нэг байх шиг. Тэр нь эдийн засгаа аваад явах том хэмжээний үйлдвэр бараг байхгүй.**

-Монголчуудын нэг зовлон наадах чинь мөн. Манай нийт аж ахуйн нэгжийг хараад үзэхэд 96 хувь нь 50 хүрэхгүй ажилтантай. Бүх салбар маань маш олон аж ахуйн нэгжүүдээс бүтсэн. Цөөхөн хэдэн томоохон үйлдвэртэй. Тэр нь явж явж хувьцаат компани байдаг. Олон хөрөнгө оруулагчтай гэсэн үг. Өөрөөр хэлбэл, аль ч салбарт хамгийн багадаа 100, түүнээс дээш ажилчидтай компаниуд л хоорондоо өрсөлдөөн бий болгодог. Наад захын жишээ

авъя л даа. Тэр 50 хүрэхгүй ажиллагсадтай компаниуд чинь бүгдээрээ нэг нэг захиралтай байх нь. Бүгд нэг нэг нягтлантай байна. Ингээд цааш хөвөрнө. Ингэхээр үйл ажиллагааны зардал нь 100 газарт давтагдаж төлдөг байна гэсэн үг. Хэрэв томоохон компаниудын бүтцийг хараад үзэх юм бол өнөөгийн 10 компанийн арван захирал, 10 нягтлантай ажлыг хоёрхон хүн хийж болоод байна. Ингэхээр жижиг компаниуд маш үргүй, маш их хэмжээний зардал гаргадаг. Дээр нь бүгдээрээ зээлтэй. Зээлийн хүү нь ч компанийнх нь үндсэн зардалд орж явдаг. Эцсийн бүлэгтээ энэ олон зардал нэг байгууллагад гараад ирэхээр тухайн барааны үнэ өндөр болчихож байгаа юм. Ийм өндөр үнэлгээтэй компанийн бүтээгдэхүүнийг хэн худалдаж авах вэ. Бүтээгдэхүүнээ борлуулахыг тулд маш сайн рекламдах болно. Түүнд маш өндөр төлбөр төлнө. Арай гэж нэг бараа, бүтээгдэхүүн хийсэн ч борлуулж чаддаггүй. Зах зээлийнхээ багтаамжаас хамаараад шүү. Дээр нь бидэнд импортын маш том айдас бий. Нөгөө өндөр үнэтэй бараанаас нь хэд дахин хямд үнээр ижил бараа ороод ирнэ. Тэр хямд бараа нь өөрийн гэсэн брэнд байх жишээтэй. Манайхан түүнийг нь мэддэг. Дээр нь тэр брэнд маркетингийнхаа зардалтай ороод ирдэг. Coca Cola ороод ирлээ гэхэд түүнтэй өрсөлдөх хэцүү биз дээ. Түүнээс ч сайн ундаа үйлдвэрлээд гаргаад ирлээ гэхэд өндөр үнэтэйгээс гадна хэн ч мэдэхгүй. Манай хэрэглэгчид “хэнийг” авах билээ?

**-Coca-г л авна шүү дээ?**

-Coca Cola-гаа л авна. Дээр нь бидэнд боловсон хүчний том асуудал бий. Бидэнд ундаа хийдэг 100 технологич байхгүй. Бид чинь гуравхан саяулаа. Гэтэл ундааны технологич гэдэг бол маш нарийн мэргэжил. Асуудалтай л даа. Манай жижиг компаниудад 100 ундааны технологич байх уу?

**-Байхгүй л дээ?**

-Байх боломж ч байхгүй. Нөгөө жижиг 100 аж ахуй нэгж маань ундаа хийх хөрөнгө оруулалтаа хийчихсэн нь үнэн. Гэхдээ тэд маань бие биенээ жижиг зах зээлд барьж иддэгээ болиод хамтраад бизнес хийвэл



боловсон хүчнийхээ хувьд зардлаа ч хэмнэнэ. Бас чанаржина. 100 зээл биш ганц зээлтэй болно. Хэмжээ нь томорч болох ч 100 нөхөрт 100 төгрөгийн зээл хэрэгтэй байсан бол хоорондоо нэгдчихвэл тэр үйлдвэрийг байгуулахад 30 төгрөг л хэрэгтэй болж магадгүй байхгүй юу. 100 жижиг юм байснаас ганц том компани байвал илүү үнэ хямдарна.

### **-Дээр нь өрсөлдөгч байхгүй.**

-100 өрсөлдөгч байсан бол ганц ч өрсөлдөгчгүй болж байгаа биз. Өөр жижиг өрсөлдөгч гарч ирээд ч нэмэргүй болно. Өрсөлдөөн хаана явах вэ гэхээр боловсон хүчний өрсөлдөөн дотроо явна.

### **-Бүтээгдэхүүнээр өрсөлдөхгүй байх нь.**

-Бүтээгдэхүүнээр биш чанар дээр өрсөлдөөд явна. Хамгийн шилдэг технологич л тэнд ажиллаж байх нь. Бидний үндсэн өрсөлдөгч бол импортын бараа шүү дээ. Зуун нөхөр нэгдчихээр бид яах ёстой вэ гэхээр шударга ил тодоор ажил нь явах ёстой. Хөрөнгийн бирж дээрээ хувьцаа гаргачихвал өөрсдөө хөрөнгө оруулалт хийчихнэ. Магадгүй тэднээс гадна 100 аж ахуйн нэгж ундаа хийхийг ашигтайгаар харж байж болох байхгүй юу. Гэхдээ тэр салбар руу шууд орохоос зүрхэлж чаддаггүй. Цалин, боловсон хүчин гээд их хэмжээний мөнгө хэрэгтэй болно. Харин тэр хүмүүс яах вэ гэхээр өөрийнхөө тодорхой хэмжээний мөнгөөр хөрөнгө оруулагч болж болно. 50 захирал байсан бол тал нь болиод мөнгөө өгөөд хөрөнгө оруулалт хийчихнэ. Хөрөнгө оруулагч яадаг вэ гэхээр ТУЗ-өө батална. ТУЗ үүсэхээрээ стратеги батална. Дээр нь нөгөө 50 дотроосоо хамгийн сайныг захирлаар тавина. Компанийн засаглал гэдэг зүйл чинь жинхэнэ утгаараа үүсч байгаа юм. Хамгийн сайн захирал хамгийн сайн боловсон хүчнийг томилно. Ингээд цаашаа улам сайжраад л яваад байна. Бид яадаг вэ гэхээр нэг захирал бүхнийг шийдээд яваад байсан. Мөнгөө ч босгочихдог, стратегиа ч боддог байсан. Дээр нь өөрөө захирал болчихдог.

### **-Зардлаа хэмнээд супер хүн байгаа юм биш үү?**

-Энд алдаа гарах маш өндөр магадлалтай байхгүй юу. Эсрэгээрээ ундаа хийдэг байсан 100 жижиг нөхөр чинь нийлээд ёстой “зодолдож” байгаад хэн нь хамгийн сайн байна, түүнийг нь олж тавина шүү дээ. Өмнө нь өөрийн хүсэл зоригоороо, мэддэг чаддагаараа болдог байсан. Онох нь ононо. Гэхдээ ихэвчлэн алдаад байна. Харин 100 нөхөр тойрч сууж байгаад хэлэлцвэл нэг шийдвэр гарна аа даа. Тэр нь хамгийн сайн байхаас өөр арга байхгүй. Нэгдсэн зуун нөхөр дээр хөрөнгө оруулагч 100 нөхөр нэмэгдээд орчихно. Ард нь 200 гэр бүл байна аа даа. Тэр 200 гэр бүл юу хийх вэ гэхээр өөрийнхөө л ундааг ууна шүү дээ. Өөрөө бас худалдан авагч болчихно. Дээр нь цаашаа сурталчилна. Хөрөнгийн бирж дээр нээлттэй хувьцаат компани болчихвол телевизэд хандахгүйгээр реклам хийчхэж байгаа биз дээ. Жишээ нь, Монголын ипотекийн корпораци оны өмнө хувьцаат компани боллоо. Бүгдээрээ л хоёр долоо хоногийн турш зөвхөн тэрний хөрөнгийг босгож байгаа юм байна. 37 тэрбумыг босгох юм байна. Ийм ийм бизнес хийдэг гээд хамаг бизнесийнхээ палан төлөвлөгөөг хэлж байгаад л хөрөнгө босгосон. Улс даяараа мэдчихэж байна. Дээр нь бидэнд нэг алдаа байна. Хийсэн бүтээгдэхүүнээ л рекламдаад байдаг. Харин бид ямар хүмүүс вэ, юу хийж чадах вэ гэдгээ хэзээ ч сурталчилдаггүй. Бараанд итгэх үү, хүнд итгэх үү гэхээр сонирхолтой асуудал үүснэ. Энэ гайгүй засаглалтай компани гээд ярьж эхэлдэг. “Монгол даатгал” гэхэд л улсын байгаад хувьд шилжсэн. Маш олон жилийн соёл байгаа учраас арай илүү гэж мэдээд байдаг. Бусад даатгалын компанийг хэн бэ гэдгийг судлахаас өөр арга байхгүй. Гэхдээ хаалттай компани байдаг. Мэдээлэл нь хаалттай.

### **-Хүний насаар бол жаран жилийн дараа бид хорвоогийнхоо жамаар үгүй болно. Гэхдээ энэ компани бол байж л байна гэж гадны том компаниуд рекламддаг. Хоёр өөр ойлголт яваад байна аа?**

-Public компаниудын ганц том давуу тал байгаа юм. Нэг хүний шийдвэрээр ажлаа хийдэггүй. Манайх шиг компаниудыг нэг мундаг нөхөр удирдаж яваад байхгүй

болчихвол цаашаа хэн удирдах нь ойлгомжгүй болдог. Дампуурсан тохиолдол олон бий. Харин хувьцаат компанийн зарчмаар бол байнгын сайжруулсан хувилбар. Гадны олон улсын шинжтэй компаниудыг хараад байхад ямар байдаг вэ гэхээр ерөөсөө л хувьцаат компани. Хувиараа ганцаараа явж байгаа компани хэзээ ч байхгүй. Маш олон хөрөнгө оруулагчтай. Хөрөнгө оруулагчид нь үндсэн шийдвэрээ гаргадаг. Хөрөнгө оруулагч юу хийх ёстой вэ гэхээр төсвийг нь батална. ТУЗ юу хийх вэ гэхээр байгаа төсөвтөө юу хийх боломжтой вэ гэдэг ирээдүйн стратегиа боловсруулна. Төсөвтэй, стратегитай болчихлоо. Цаашаа түүнийг гүйцэтгэх удирдлагаа ТУЗ сонгоно. Гүйцэтгэх удирдлага ганцхан юм шаардах эрхтэй. Хувьцаа эзэмшигч ч бай, хөрөнгө оруулагч ч бай, ТУЗ ч бай ямар нэгэн байдлаар ажилд нь дарамт шахалт учруулах ёсгүй. Ажиллах боломжийг нь олгох ёстой. Мөнгөтэй, стратегитай болчихсон, харин яаж хийх мань нөхрийн авьяас байхгүй юу.

### **-Хувьцаат компаниуд ч унасан тохиолдол олон бий шүү дээ?**

-Маш олон бий. Гэхдээ голдуу ганц л шалтгаантай. Эзэмшигч нь эсвэл ТУЗ нь гүйцэтгэх захирлын ажлыг даалгаад байхаар л уначихдаг. Гаднаас нөлөөлөөд байхаар өөрийнх нь төлөвлөж байсан үндсэн ажлынх нь арга барил алга болчихно гэсэн үг л дээ.

### **-Манай одоогийн байгаа байдлын талаар эргээд ярилцъя. Яг ямар байна вэ?**

-Хөрөнгө оруулагч нь ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал. Ганц хүний шийдвэрээр л явдаг. Бид 25 жил ингэж явсан. Тэгсэн нэг ийм асуудал үүссэн.

### **-Ямар?**

-25 жил ингээд явсан компаниудад ганцхан зүйл байна. Тэр захирал буюу ХХК нь томорчихсон. Үнэхээр ч мундаг хүмүүс байжээ. Энэ хүртэл чирээд аваад ирчихсэн. Гэхдээ хараад байхаар тэр хүмүүс маань 30 -40 орчим насны хооронд бизнесээ эхэлсэн

байна. Одоо нас явчихсан. Тэтгэвэрт гарах хэмжээний болсон. Нас харьж байна. Байнга өмнөх шигээ эрч хүчтэй байгаад байхгүй. Эрсдэлээс халшрах болсон. Тэдэнд гурван сонголт л үлдсэн. Өвлүүлэх үү эсвэл компаниа зарах уу, үгүй бол нээлттэй болгох уу гэсэн гурван сонголт. АНУ-ын бизнесийн түүхийг харахад бас л ийм сонголттой тулж байсан байгаа юм. Өвлүүлсэн олон тохиолдол байгаа л даа. Гэхдээ өвлүүлснүүд нь дандаа үрэгдсэн байдаг юм.

### **-Хоёр дахь үесээ муудаад гурав дахиаа л байхгүй болдог юм шиг ээ, тийм үү?**

-Хоёр дахь үе нь жаахан авч явна. Охин юм уу, хүү нь аавтайгаа хамт бизнес хийж байсан учраас байгаад байгаа юм. Гэхдээ сайжруулахгүй л дээ. Харин гурав дахь дөрөв дэх үеэсээ уруудсаар ямар нэгэн байдлаар зарагдаад л дуусдаг түүхтэй. АНУ-ын хамгийн мундаг IPO хийсэн компаниудыг хараад байгаарай. "Америкийг босгосон эрхмүүд" гээд нэг кино гараад байна аа даа. Тэр нөхөд чинь бүгдээрээ public болсон. Форд байна. Өөрсдөө тодорхой хэмжээний хувьтай. ТУЗ-д нэг суудалтай. Гэхдээ өөрсдөө гүйцэтгэх захирал болдоггүй. Ирээдүйгээ харвал хамгийн шилдэг нь л гүйцэтгэх захирал хийх ёстой биз дээ. Би байхаараа хамгаалаад байна гэсэн үг биш байхгүй юу. Харин нэг нөхөрт 100 төгрөг өгчөөд 200 болгуулаад байвал дээр биз дээ. Өөрөө байхаараа 100 төгрөгөө бариад тэмцээд байдаг. Тэгж тэгж 150 болгодог. Гэхдээ 200 нь хамаагүй өндөр үр дүн байгаа биз дээ. Public-ийн давуу тал нь болохоор өөрөө маркетинг юм байна. Өөрөө менежментээ сайжруулчихдаг юм байна. Хамгийн чухал нь хөрөнгө оруулагчид бүгдээрээ тэр компанийн талаар санаа зовно. Унагаах гэж хувьцааг нь худалдаж авахгүй биз дээ. Энэ ирээдүйтэй бизнес учраас хөрөнгө оруулъя гээд хувьцааг нь худалдаж авч байгаа юм. Ингэхээр өмнө нь нэг толгой санаа зовдог байсан бол хувьцаат болсноор хувьцааг нь худалдаж авсан хүн болгон санаа зовдог болно.

### **-Манай Хөрөнгийн биржээс хараад байхад нэг юм анзаарагддаг. Нөгөө хувьцаагаа зардаг ч үгүй. Нэг нөхөр хувьцаа эзэмшигч**



**гээд байж л байдаг. Үнэ нь ч өсдөггүй. Энэ юутай холбоотой вэ. Жамаараа явахгүй байна уу?**

-Жамаараа байгуулагдаагүй зүйл ямар нэгэн гажигтай байдаг даа. “Монгол шуудан” бол хамгийн амжилттай явах ганц жишээ. Энэ компани хувьцаат болсноор Монгол Улсад хамгийн анх удаа хамгийн зөвөөр ТУЗ нь бүрэлдсэн. Бага хувьцаа эзэмшигчид нь ард түмнээ төлөөлөөд орж байна. Үндсэн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл ТУЗ-д нь орж байна. Анхнаасаа төслийг нь харж байгаад хувьцааг нь шударгаар худалдаж аваад явсан хүмүүс бол анх юу амлаж байсан түүнийг нь хүлээнэ. Мөрийн хөтөлбөртөө юу амлаж байсан түүнийгээ хийхийг нь харна гэсэн үг. Харин манайд анх Хөрөнгийн бирж байгуулагдаж, компаниудыг хувьчилж байх үед юу болсон бэ гэхээр юугаа ч мэдэхгүй хүмүүст хувьцаа тараачихсан. Зарим нь ийм хувьцаатай гэдгээ ч мэдэхгүй. Тэгсэн нэг хэсэг нь цуглуулаад аргаа олсон. Тухайн компани нь тодорхой хэмжээний бизнес хийдэг ч яаж илүү ашигтай ажилладаг юм, хөрөнгө зах зээлээс хэрхэн мөнгө босгодог вэ гэдгийг сайн таниагүй хүмүүс болохоор ямар ч сурталчилгаа хийдэггүй. Ийм болохоор манай маш болон хувьцаат компани банкинд зээлтэй байгаа. Зөвхөн банкнаас мөнгө босгож болдог гээд тийшээ яваад байна. Гэтэл сүүлийн үед “Монгол шуудан”, “МИК”-ийн IPO-гийн жишээнээс хараад бусад хувьцаат компаниуд маань эргэж хөрөнгийн захаа харж байна л даа. Манай хувьцаа чинь юу билээ. Нэмэлт хувьцаа гаргах боломж бий бил үү гэдгийг харж эхэлсэн.

**-Танайд нэмэлт хувьцаа гаргахаар хандаад эхэлсэн гэсэн үг үү?**

-Тийм. Манайд нэлээд хэд хэдэн компани хандсан. Бид ганц л шаардлага тавина. Нэмэлт хувьцаа чинь юунд зарцуулагдаж, яаж өгөөжөө олох ёстой юм. Та нарт хөрөнгө оруулагч юу бодож орж ирэх ёстой юм. Тэрийгээ л сайхан үзүүл, сурталчлах ёстой гэж. Ингээд хөрөнгө оруулагч ороод ирэхээр зээлийн хүү гэж юм байхгүй шүү дээ. Хувьцаанд хүү байхгүй. Ашгаа олсны дараа ноогдол ашгаа тараадаг бизнес.

Ингэхээр ямар давуу тал гарч ирэх вэ гэхээр зээлийн хүү гэдэг юм тухайн компанид байхгүй болно. Ингэхээр өрсөлдөж эхэлнэ. Үүнийг дагаад зардал багасна. Зардал нь багасчихсан байхад хөрөнгө оруулагч нь нэмэгдэхээр худалдан авалт бий болно.

**-Ингэж мөнгө босгох боломж байхад манай компаниуд бүгдээрээ л бор зүрхээрээ яваад байгаа юм байна. Нэг ёсондоо зээлийн хүү төлөхийн тулд үйл ажиллагаа явуулаад байна уу?**

-Ашиг биш зээлийн хүүгээ л төлөх гэж явна. Маш олон аж ахуйн нэгжийн захирал тэгэж ярьдаг. Сүүлийн хорин жил би бизнес хийлээ. Хараад байсан чинь хийсэн, бүтээсэн юм бол байна. Гэхдээ өөрийгөө харсан чинь үлдсэн юм алга. Гэтэл тэр бүхэнд насаа зориулчхаж гэдэг.

**-Ашиг нь банкинд оччихсон...**

-Өөр нь байх ёстой ашиг нь банкинд оччихсон. Зээлийн хүүгээр дамжаад. Банкууд илүү өндөр байшинг бариад л байдаг. Нөгөө нөхөр нь анх эхлүүлсэн байшин дотроо байгаад л байдаг.

**-Байшин нь муудаад байдаг. Засъя гэх нь ээ хөрөнгө хомс.**

-Тэгээд байж байтал өөр нэг нөхөр гараад ирдэг. Илүү том зээл аваад надаас илүү хямдхан бараа гаргаж ирээд шахалт үзүүлээд байдаг. Ингээд бид бие биесээ барьж иддэг л тоглоомтой болчихоод байна. Уг нь тухайн салбарт 10 жил ажилласан нөхрийн өөрийн арга барил гээд нэг юм үүсэх ёстой доо. Төгс биш юмаа гэхэд бага. Түүн дээр дараагийн хөрөнгө оруулагч нэгдээд улам сайжруулах ёстой байтал цоо шинэ юм оруулж ирээд биесээ барьж идэх ёсгүй байхгүй юу. Би буузны салбарт харамсдаг.

**-KFC, пиццанд зах зээлээ алдчихсан гэж үү?**

-Манайхан чинь нэг хэсэн “хаан”, “заан”-аас нь авхуулаад “начин” хүртэл бууз хийлээ шүү дээ. Тус тусдаа. Янз бүрийн зардлаар л жижиг жижиг цайны газрууд нээгээд л.

Баахан хөрөнгө оруулалт хийгээд барьсан. Арай гэж тэмцээд байж байтал оройн хоолны зах зээлийг нэг сүйхээтэй нөхөр бодож олоод л “Ерөөсөө л энэ салбарыг барьж авъя. Их мөнгө эргэлддэг юм байна” гээд гаднаас KFC оруулаад ирсэн. Одоо Burger King орж ирж байна. Дээр нь янз янзын пицца оруулсан. Эд яасан бэ гэхээр их хэмжээний зээл аваад гаднаас ч бай дотоодоос ч бай ямар нэгэн хөрөнгө босгоод л бүр брэндтэй нь оруулаад ирсэн. Уг нь “хаан”, “заан” бууз чинь бидэндээ сайхан брэнд шүү. Гэтэл зах зээл дээр гадны нөхдөд л тавиулчихсан. Магадгүй ирээдүйд Mac Donald's орж ирэх байх. Тэгвэл буузыг цагаан сараар л иддэг болох байх даа.

### **-Тэгээд яах ёстой байсан юм бэ?**

-Манай буузныхны үндсэн технологи нь дуусчихсан байж магадгүй байх. Яаж хямдханаар хийж хэрхэн түгээх вэ гэдэг дээрээ зогсчихсон байж болно. Тэр үед гаднаас юм оруулж ирсэн нөхдүүд нөгөөдөхдөө хөрөнгө оруулалт хийгээд гадны янз бүрийн технологи оруулж ирээд хөгжөөд явсан болчих байсан юм. Гадны технологи чинь үнэтэй. Гэхдээ тэрийг манайхан брэндээс нь болоод худалдаж аваад байна. Эсвэл тэднийг орж ирэхээс нь өмнө “Хаан” юм уу “Заан” буузныхан өөрсдийгөө аварч болох байсан. Public болчих байсан юм. Ард түмний компани болчихсон байсан бол хувьцаа эзэмшигч нь яаж ч байсан өөрийнхөө өмчид л хөрөнгө оруулалт хийнэ шүү дээ. Сая гэхэд л “Монос”-ынхон шийдвэр гаргаад ард түмний компани болох гэж байна. Энэ бол гадны том өрсөлдөгчөөс өөрсдийгөө хамгаалж эхэлж байгаа юм. Магадгүй гадны эм үйлдвэрлэдэг том нөхдүүд ороод ирвэл шууд л манай эм нийлүүлэгчдийг унагаана. Буузаа алдсан шиг.

**-Энэтхэгийн эм нийлүүлэгчид гэхэд л хэд дахин хямд үнэ санал болгох байх л даа.**

-Ерөнхийд нь тооцсон байна гэсэн. Манайхан багц эмийг 1000 төгрөгөөр хийдэг бол нөхдүүд бараг 10 төгрөгөөр хийдэг юм шиг байна лээ. Боловсон хүчний зардал гэж

бараг байхгүй шахуу газар. Энэтхэгт эмийн ургамал ургахгүй, байхгүй гэсэн асуудал байхгүй. Тэд чинь том газар нутагтай. Халуун ч гэсэн нарийн ургамал нь их ургана. Дээр нь англичууд техник, технологийн хувьд маш сайн хөрөнгө оруулалт хийчихсэн. Тэгэхээр хамгийн чанартай эм хамгийн хямдаар тэнд хийж байна. Тэр нөхдүүд ороод ирвэл манай босох гэж байсан хэдэн нөхдүүдийг үйлдвэр барихгүйгээр л унагаачихна. Тэд нар бол манайд орж ирээд л хүмүүстэй нь, уур амьсгалтай нь судалгаа хийчихнэ. Ийм өвчнөөр их өвддөг юм байна гээд тэрийг нь эмчлэх эмийг хамгийн хямдханаар оруулаад ирнэ. Эхлээд бид нар жилдээ нэг эм уудаг болно. Дараа нь хагас жилд, цаашлаад улиралд, сүүлдээ өдөртөө нэг эм уудаг болно. Америкчууд чинь тийм биз дээ. Өдөр болгон витамин уухгүй бол хүүхдийн чинь шүд тийм болно. Үс чинь унана гэдэг. Хар багаасаа л хүүхдүүд нь витамин уудаг болчихсон. Унтах болгондоо гурваас дөрвөн төрлийн витамин ууж байх жишээний. Тийм байдалд бид нар очих нь ээ. Уг нь бид чинь өөрсдийн махнаасаа тэжээл авдаг. Бэлчээрийн малын нэг давуу тал нь хамгийн шимтэй өвс, эм ийн ургамлыг түүж иддэг. Тийм болохоор мах нь тэр чигээрээ витамин. Тийм махаар бид тэжээгддэг байсан бол одоо малаа тэжээдэг болсон. Ингэхээр сүүлдээ витамин уугаад унтахаас өөр аргагүй л болох нь л дээ. Тийм болохоор л бид өдий хүртэл хийгээд ирсэн зүйлээ алдана гэдэг хариуцлагагүй явдал биш нүгэл. Тэр бүхнийг хамгаалах ёстой. Ганц хүн зээл аваад явбал хамгаалж чадахгүй. Нийтээрээ л нэгдэх ёстой. Нийлчихсэн байхад цохиж унагаахад хэцүү шүү.

**-Монголд нэгдээд дийлдэхгүй байгаа ганц ч болов жишээ байна уу?**

-Байна. Манай “АПУ” болоод “Сүү” ХК-ийн бизнесийн маш олон компани авах гэж оролдсон. Амжилт олсон нь байна уу?

**-“MCS” байгаа юм биш үү?**

-Үгүй ээ, байхгүй. Колагаар цохиж унагаах гэж оролдоо. Гэхдээ “АПУ”-ийнхан “Тэрэлж”, “Сэлэнгэ” ундаагаа зарсаар л байгаа. Усаа, архиа, пивоо зарсаар л байна. Ялангуяа тэр



“Боргио” бол дийлдэхгүй шүү. Түүнийг нь дийлэх пиво орон нутагт л лав байхгүй. Яагаад вэ гэхээр ард нь 3800 хөрөнгө оруулагч санаа зовж байна. Тэдний ард гэр бүл нь бий. Байгуулагдсан оноосоо хуримтлуулсан компанийн соёл, өв, хийх аргачлал гэсэн дийлдэхгүй засаглал гэдэг зүйл байгаад байдаг. Энэ нь компаниа аваад яваа л байгаа юм. Энэ салбар руу орж байгаа бусад компаниудын хувьд мэдээж өндөр өртөгтэй. Цоо шинээр соёл бий болгоно. Их хугацаа орно. Амархан биш л дээ. Хэвлэлийн салбарт ч тийм зүйл байгаа биз дээ.

**-Манай зах зээлийг гадны том компаниуд эзэлж авахад амархан юм байна. Тэгвэл яагаад хөрөнгө оруулалт нь буураад байгаа юм бэ?**

-Манайд хөрөнгө оруулалт яаж хийдэг байсан бэ гэдэгт учир байгаа юм. Монголд нэг ийм хүн байна. Газартай, үндсэн санаатай Батаа гэдэг хүн байгаа юм. Мань хүн гадны хөрөнгө оруулалтыг татна. Женни гэдэг нөхөр байх нь л дээ. Цүнх дүүрэн мөнгөтэй нөхөр. Тэгсэн Батаа, Женни хоёрыг танилцах нь. Танилцаад хамтарсан компани байгуулж. Хамтарна гэдэг чинь хурим хийж байна гэсэн үг. Манай Батаа яадаг вэ гэхээр хөрөнгө оруулалтаа хамт хийнэ гэснээ маргаашнаас нь нөгөө муу Женнигээ “амбаардаад” эхэлдэг. Түүнээс гадна хөөх гэж оролдоно. Өөрийнхөө хувийг өсгөх гэнэ.

**-Энэ баялаг чинь минийх, чи юу юм гэж үзнэ...**

-Нэлээн ядраана даа. Тэрнээс гадна Женни чинь шууд цүнх дүүрэн мөнгөтэй орж ирэхгүй. Талтай нь орж ирээд, талыг нь технологи болгоод ороод ирнэ. Тэгсэн Батаа зангаа хувиргаад эхэлсэн. Хурим хийсэн хүмүүс болохоо байхаар яадаг билээ.

**-Сална.**

-Салах болсон болохоор Женни яадаг вэ гэхээр гүйж очоод олон улсын шүүхэд очоод гомдол гаргачихна. Гомдол гаргахаар яадаг вэ гэхээр бусад Женнинүүд “Өө эд нар чинь

бүтэхгүй нөхрүүд байна” гээд л Монголыг сонирхохоо больчихно. Нэг ийм түүх байна.

**-Өөр ямар түүх байна?**

-Хоёрдугаарт манай валютын ханш үнэхээр дарамттай. Хөрөнгө оруулалт хийнэ. Тэд валюттайгаа ороод ирнэ. Тэгээд төгрөг болгох ёстой. Төгрөг болгосон хойноо төгрөгөөр бол ашиг хийж чадаж байгаа юм. Тэгээд гарах болсон чинь төгрөгөө валют болгоно оо доо. Тэгсэн манай төгрөгийн ханш суларчихсан байдаг. Буцаад доллараа авъя гэхээр эцсийн дүндээ 100 доллартай орж ирсэн нөхөр 80 доллартай буцах болно. Уг нь манайд ашиг олсон нь үнэн. Гэхдээ валютын ханшийн зөрүүнд ашиггүй болчихдог. Яалт ч байхгүй хөрөнгө оруулчихсан хүмүүс чинь төгрөгийнх нь ханш чангарахыг хүлээгээд байгаад л байна. Гэхдээ зүгээр суухгүй. Бидэнтэй адил гадныхан биенээ танина. Хөрөнгө оруулсан нөхрөөс юу болж байгааг нь асууна. Тэгэхээр “Би гарч чадахгүй байна”. Бизнес болж байгаа ч би өгөөжөө авч



чадахгүй байна. Эндхийн иргэн болно доо гээд сууж байх жишээтэй.

#### **-Тэрийг сонсоод нөгөө хөрөнгө оруулах нөхөр больчихно.**

-Тэгнэ. Би ийшээ хөрөнгө оруулбал Монголын иргэн болох юм байна гээд болино. Гэхдээ түрүүн хурим хийдэг тухай ярьсан даа. Тэр хоёр чинь уг нь болзох хэрэгтэй. Танилцаж, хамт хоол идэж, хамтарч амьдарч үзэх ёстой. Амлалтгүйгээр тандах хэрэгтэй. Ингэхэд юу хэрэг болдог вэ гэхээр санхүүгийн ертөнцөд бонд хэрэгтэй болдог. Батаа маань бонд гаргаад гадны хөрөнгө оруулагч бондыг нь худалдаад авчихсан бол бизнесээ хийж эхэлнэ. Бондын төлбөр гэж байх ёстой. Тэрийгээ төлөөд л байвал Батааг ажил хийдэг юм гэж танилцаж эхэлнэ ээ дээ. Дараа нь хамт хоолонд орно. Дахиад бондоос нь худалдаж авна. Сүүлдээ хамтарч амьдардаг болно. Маш олон Батаа бий. Бондыг нь худалдаж авдаг. Төлбөрөө төлөөд байвал өөр төлбөрөө төлөхгүй байгаа нөхрийн бондыг Женни маань өөр хүнд зарчихаж чадна. Заавал шүүх дээр очоод хэрүүл хийж, гомдоод байх шаардлагагүй. Ингэхээр зөв аргаар бид танилцаж эхэлж байна. Батаа нэг өдөр бодож эхэлнэ. Бүр томроё гэж. Бүр том төсөлтэй орж ирнэ. Би ийм байсан, тийм болох гэж байна. Мөнгөө төлөөд байсан гээд ороод ирэхээр Женни маань бүрэн утгаараа орж ирнэ. Хурим хийхэд бэлэн байна гэсэн үг. Гэтэл бид яагаад байна вэ гэхээр нэг Батаа, нэг Женниг шууд л хурим хийлгэх гээд зүтгээд байна.

-МАН-ын хувьд бондыг өр гээд л үзээд байгаа!

-Аливаа бизнест ямар нэгэн эрсдэл бий. Хамгийн эрсдэл багатай бонд бол Засгийн газрын бонд. Засаг бол төлнө.

#### **-Улс учраас...**

-Тийм.

**-Гэтэл улс чинь бас дампуурч байна шүү дээ. Грек дампуурчихлаа. Бид араас нь орох нь гэсэн таамаг сөрөг хүчинд байна.**

-Грекийн асуудал бол өөр. Ямар учиртай вэ гэхээр, барьцаагаар зээл авчихсан баахан компани, хувь хүмүүс тэнд бий. Тэр нөхдүүд яадаг вэ гэхээр банкнаас авсан зээлээ төлдөггүй. Барьцаалсан хөрөнгө нь байгаад байдаг. Хөрөнгийг нь банк битүүмжлээд хөрөнгийг нь авна гэхээр Иргэний хуулиараа болдоггүй. Барьцааны хөрөнгийг нь авъя гэвэл манайх шиг таван жил явна. Манайд ч зээлээ төлж чадахгүй яадаг вэ гэхээр нэг заалт байгаа юм. Дуудлага худалдаагаар зарна гэж. Дуудлага худалдаагаар зарж олсон мөнгөнөөсөө зээлээ төлнө гэдэг.

#### **-Манайх чинь эсрэгээрээ хураагаад авчихдаг юм биш үү?**

-Шууд хураагаад авах боломжгүй. Таван жил явна. Харин банк бусууд авчихдаг. Яадаг вэ гэхээр барьцааг нь авахдаа нэрийг нь шилжүүлээд авчихсан байдаг. Машин лизенг авахаар өөрийнхөө нэр дээр болгочоод мөнгө өгдөг. Зээлээ төлөөд дууссан үед буцааж шилжүүлэх болзолтойгоор. Арилжааны банкууд тэгэх боломжгүй. Яагаад гэвэл их хэмжээний мөнгө зээлдэг учраас.

#### **-Машины зээл банкнаас авахад нэрийг нь өөрсдийнхөө нэр дээр л шилжүүлдэг шүү дээ.**

-Хөдлөх хөрөнгө бол тийм. Үл хөдлөх хөрөнгийг тэгэхгүй л дээ. Бизнесийн зээл бас өөр.

#### **-Манай банкны хүү маш өндөр. Жилийн бараг 72 хувийн хүүтэй. Бууруулж болдоггүй юм уу. Юунаас болоод байна вэ?**

-Банкны хадгаламжийн хүүтэй зээлийн хүү уялдах ёстой. Хадгаламж эзэмшигчид 12 хувийн хүү санал болгоод авсан бол түүнийгээ өсгөх байж л ашигтай ажиллана. Банк зээл олгохдоо тэр хэмжээний мөнгийг эрсдэлийн сандаа байлгах ёстой. Гэхдээ тэр сангийн мөнгө өсөхгүй. Зүгээр л хадгалж байна гэсэн үг. Иймэрхүү эрсдэлд орсоор байгаад Грекийн банкууд дампуурсан. Грекийн банкны барьцаанд зөндөө хөрөнгө бий. Гэхдээ худалдаж чаддаггүй. Манайд ийм асуудал байна. Чанаргүй зээл бараг нэг их

наяд төгрөг болж байна. Энэ зээлийн цаана эрсдэлийн санд багаар бодоход 500 тэрбум төгрөг барьж байх ёстой. Тэр 500 тэрбумыг хадгаламж эзэмшигчдээс авсан. Тэдний хүүг төлөөд л суугаад байна гэсэн үг. Энэ нь өөрөө аюултай. Тэгсэн актив тал дээрээ ямар ч хүү авч чадахгүй байгаад байна. Тэр нэг их наядын цаана хоёр их наядын хөрөнгө байж магадгүй байхгүй юу.

**-Цэц дээр яг энэ асуудлаар шийдвэр гаргасан. Барьцааны хөрөнгийг шилжүүлэх нь иргэний эрхийг зөрчиж байна гэсэн.**

-Тийм. Гэхдээ наад иргэний эрх чинь эдийн засгийг унагаагаад байгаа юм. Хүн бизнес хийнэ гээд хөрөнгөө барьцаалаад зээл авсан бол төлөх ёстой. Чадахгүй бол хөрөнгөө хураалгах ёстой. Иргэний эрх гээд яриад байна. Арилжааны банкинд хөрөнгө оруулалт хийчихсэн хадгаламж эзэмшигч зөндөө байгаа биз дээ. Гэтэл арилжааны банк тэдний хүүг төлөх гэхээр зээл авсан нөхөр нь мөнгөө төлөхгүй болохоор баахан хүний хөрөнгийг л унагааж байна гэсэн үг.

**-Банкны хүүг яаж бууруулах вэ?**

-Банкууд бас нэгдэх ёстой. АТМ л гэхэд баахан байна. Бүгд нэгнийхээ эсрэг салбар нээж, баахан ажилтан авах ямар хэрэгтэй юм. Нэг нь нэг суманд салбар нээхээр нөгөө нь нээхээс өөр аргагүй болдог. Тийм болохоор 16 биш нэгдээд найм болчихвол нөгөө 100 компани шиг зардал буурна. Зардал буурвал хүүгээ багасгах боломжтой. 16 нөхөр хүмүүсээс мөнгө татна гэхээр хоорондоо өрсөлдөх болно. Хадгаламж эзэмшигч яадаг вэ гэхээр “Тэрбум төгрөг байна. Ямар хүү өгөх вэ” гэхээр нэг үнэ хэлнэ. Хадгаламж эзэмшигч тэгвэл нөгөө банкинд хандана. Банк яаж ийм байгаад авч үлдэхийг бодно. Жижиг хадгаламж эзэмшигчийг бол тогтсон хүүгээр авч байгаа. Том хадгаламж эзэмшигчид бол хүүгээр л тоглодог. Ингээд дээрэлхүүлж байж мөнгө авсан банк өөр хэн нэгнийг хүүгээр дээрэлхэн. Ийм л юм байгаа юм. Хаалттай зал зээлийн сул тал нь энэ.

**Эх сурвалж: Л.НАРАНТӨГС  
news.mn**





**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ  
ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ**

ТӨГСӨЛТИЙН БАЯР



Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2015 оны 3 дүгээр сарын 24-ноос 4 дүгээр сарын 1-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2015 оны 4 дугаар сарын 27-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

*Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье*



### Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	533,103
Нийт үнийн дүн /төг/	14,328,898,923
Хэлцлийн тоо	1,446
Арилжигдсан үнэт цаасны тоо	69
Зах зээлийн үнэлгээ /төг/	1,297,295,579,978


### ТОП-20 индекс

Хаалт	11,082.62
Өөрчлөлт /%/	-7.40

### MSE ALL индекс

Хаалт	802.93
Өөрчлөлт /%/	-6.92

### ТОП 20 ИНДЕКС



### Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:				Үнийн дүнгээр:			
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	№	Симбол	Үнэт цаасны нэр	Үнийн дүн
1	TTL	ТАВАН ТОЛГОИ	158,041	1	APU	АПУ	228,995,906
2	APU	АПУ	62,190	2	TTL	ТАВАН ТОЛГОИ	145,464,171
3	MRX	МЕРЕКС	46,036	3	GOV	ГОВЬ	29,980,205
4	RMC	РЕМИКОН	19,690	4	TCK	ТАЛХ ЧИХЭР	20,465,030
5	JTB	ЖЕНКО ТУРБЮРО	19,488	5	NEH	ДАРХАН НЭХИИ	17,649,720

### Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	HML	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИ	470.00		49.21
2	TEX	ТЕХНИКИМПОРТ	2,800.00		32.01
3	BUK	УБ БУК	35,000.00		16.67
4	BBD	СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП	123.49		14.99
5	MB	МОНИНЖ БАР	126.00		14.42

### Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	TTL	ТАВАН ТОЛГОИ	870.03		-53.94
2	BAN	БАГАНУУР	1,400.00		-41.03
3	BEU	БЭРХ УУЛ	1,000.00		-39.39
4	SHG	ШАРЫН ГОЛ	2,047.00		-38.90
5	SHV	ШИВЭЭ ОВОО	2,249.00		-31.64

### Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ЗГХБ-Б-28-360	31,386	2,905,653,108	92,578	28	14.930
2	ЗГХБ-Б-156-361	9,000	900,000,000	100,000	156	15.750
3	ЗГХБ-Б-39-362	969	87,175,116	89,964	39	14.915
4	ЗГХБ-Б-12-365	72,168	6,983,769,528	96,771	12	14.500
5	ЗГХБ-Б-52-366	32,408	2,820,533,056	87,032	52	14.941

### Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Дээд ханш	Доод ханш	Сүүлчийн ханш
1	ZGEB-BL-25/07/16-A0094-0	10	945,000	94,500	94,500	94,500
2	ZGEB-BL-31/08/16-A0108-0	22	2,058,100	93,550	93,550	93,550
3	ZGEB-BL-16/05/16-A0111-0	903	88,494,000	98,000	98,000	98,000
4	ZGEB-BL-16/05/16-A0111-0	11	1,078,000	98,000	98,000	98,000
5	ZGEB-BL-16/05/16-A0111-0	152	14,909,680	98,090	98,090	98,090
6	ZGEB-BL-25/07/16-A0094-0	3	285,900	95,300	95,300	95,300